



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/355

Номгон

Хээрийн судалгаа, шинжилгээ, хайгуул
хийх ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2, 16.1.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай 12/54 дүгээр тогтоолын хавсралтын 1.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түүх угсаатны зүй-байгалийн түүхийн музейн сан хөмрөгийг байгалийн үнэт чулууны цуглуулгаар үзмэрийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулах хээрийн судалгаа, шинжилгээ, хайгуул хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Р.Пүрэвсүрэн	Түүх угсаатны зүй, байгалийн түүхийн музейн захирал
Гишүүд: Р.Мэндбаяр	Тагнуулын хэлтсийн дарга
У.Балжинням	Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
С.Эрдэнэмөнх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
Д.Содномсамдан	Байгаль орчин аялал жуулчлалын газрын ахлах Мэргэжилтэн
Д.Насантогтох	Музейн Эрдэм шинжилгээний ажилтан
Т.Батсүрэн	Музейн тайлбарлагч
Б.Эрдэнэхуяг	Бүртгэл мэдээллийн санч
Г.Цэрэн	Ахмад геологич

641310909


2.

Р.Буян

Хөөрөг урлаач (зөвшилцсөнөөр)

2.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж тайлагнахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг), ажлын хэсгийн ахлагч (Р.Пүрэвсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН